



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
БАЙГАЛЬ-ЭХ ЛИЦЕЙ
АХЛАХ СУРГУУЛЬ
ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 2/44

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай


МУИС-ийн Байгаль-Эх лицей ахлах сургууль, Экологийн боловсролын төвийн дүрэм"-ийн 3.4.1 заалт, 2018 оны 09 дүгээр сарын 27-ний өдрийн Багш нарын зөвлөлийн хурлын санал, 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль-Эх лицей ахлах сургуулийн захирлын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/22 тоот тушаалын "Элсэлтийн ерөнхий шалгалт, төрөлжсөн олимпиадын болон гүнзгийрүүлсэн хичээл заасан үндсэн багшийн ажлын үр дүнг тооцох" журмын 2 дахь зүйлийн 2.1, 2.2, 2.3 дахь заалтуудыг дараах байдлаар өөрчилсүгэй.

2. Журмын 2 дахь зүйлийн Суралцагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын амжилтаар багшийн ажлыг үнэлэх хэсгийн:

- 2.1. Мэргэжлийн өндөр ур чадвар, идэвхи санаачилга гарган ажиллаж, тухайн хичээлээр бэлтгэсэн нийт суралцагчдынх нь элсэлтийн ерөнхий шалгалтад авсан онооны дундаж, тухайн хичээлийн жилийн сургуулийн зорилтод оноонд хүрсэн бол багшийг нэг сарын үндсэн цалингаар урамшуулна.
- 2.2. Сургуулийн зорилтод оноонд хүрээгүй боловч бэлтгэсэн суралцагчдын дотроос 1-5 сурагч 800 онооны болзол хангасан бол багшийн сарын үндсэн цалингийн 50 хувиар, 6 болон түүнээс дээш суралцагч 800 оноо авсан бол сарын үндсэн цалингаар тус тус урамшуулна.
- 2.3. 2.1 болон 2.2 заалтыг тус тус хангасан тохиолдолд урамшууллыг давхардуулан олгож болно.

ЗАХИРАЛ



П.ТҮВШИНТӨР

41408010-

Захирлын 18 оны 10 дугаар
сарын 23-ны өдрийн 1/4 дугаар
тушаалын 1 дугаар хавсралт

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ, ТӨРӨЛЖСӨН ОЛИМПИАДЫН БОЛОН ГҮНЗГИЙРҮҮЛСЭН ХИЧЭЭЛ ЗААСАН ҮНДСЭН БАГШИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ТООЦОХ

Зорилго: Багшийн хүүхэд нэг бүрийг төлөвшүүлэх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, бүтээлч үйл ажиллагаагаар хүрсэн үр дүнг үнэлэх.

Үндэслэл:

- БСШУ-ны сайдын 2002 оны 333 дугаар тушаал
- МУ-ын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт
- БСШУ, НХХ, Сангийн сайд нарын 2007 оны 307/91/237 дугаар хамтарсан тушаал

1. Төрөлжсөн олимпиадыг үнэлэх

Бэлтгэсэн шавь нь улсын төрөлжсөн олимпиадад амжилттай оролцож, дараагийн даваанд шалгарсан бол багшид дараах байдлаар цаг олгоно.

- Дүүрэгт оролцож, нийслэлд оролцох эрх авсан бол 40 цаг
- Нийслэлд орж, улсад оролцох эрх авсан бол 30 цаг
- Улсад орж, эхний арван байранд багтсан бол 30 цаг

2. Суралцагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын амжилтаар багшийн ажлыг үнэлэх

2.1 Мэргэжлийн өндөр ур чадвар, идэвхи санаачилга гарган ажиллаж, тухайн хичээлээр бэлтгэсэн нийт суралцагчдынх нь элсэлтийн ерөнхий шалгалтад авсан онооны дундаж, тухайн хичээлийн жилийн сургуулийн зорилтод оноонд хүрсэн бол багшийг нэг сарын үндсэн цалингаар урамшуулна.

2.2 Сургуулийн зорилтод оноонд хүрээгүй боловч бэлтгэсэн суралцагчдын дотроос 1-5 сурагч 800 онооны болзол хангасан бол багшийн сарын үндсэн цалингийн 50 хувиар, 6 болон түүнээс дээш суралцагч 800 оноо авсан бол сарын үндсэн цалингаар тус тус урамшуулна.

2.3 2.1 болон 2.2 заалтыг тус тус хангасан тохиолдолд урамшууллыг давхардуулан олгож болно.

3. Нэмэлт ажлын хөлс тооцох

Гүнзгийрүүлсэн хичээл заасан үндсэн багшид нэг суралцагчийн нэмэгдэл зардлын 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт хөлс олгохыг тухайн багштай байгуулах хөдөлмөрийн гэрээнд тусган шийдвэрлэнэ.